

## **МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙГ ГАДААДАД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХЭД ЗУУЧЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ**

### **Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын иргэнийг гадаадад улсад цалин хөлстэйгээр хөдөлмөр эрхлэх болон дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхлэх, зуучлагч болон зуучлуулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Монгол Улсын иргэн /цаашид “иргэн” гэх/-ийг гадаадад хөдөлмөр эрхлэх болон дадлагажихад зуучлах үйлчилгээг “Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэх эсхүл дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл”-тэй аж ахуйн нэгж /цаашид “зуучлагч” гэх/ эрхлэн явуулна.

1.3 Зуучлагч хүлээн авагч улсын ажил олгогчтой байгуулсан гэрээ, ажлын байрны тавьсан шалгуурт нийцүүлэн Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд болон дадлагажихад зуучлахаар бүртгэх, сонгон шалгаруулалтад хамруулах, мэргэжлийн бэлтгэлийг хангуулах, зуучлалын гэрээ байгуулах, зуучлуулагчид дэмжлэг үзүүлэх зэрэг үйлчилгээг зохион байгуулна.

### **Хоёр. ЗУУЧЛУУЛАГЧИЙГ БҮРТГЭХ, СОНГОН ШАЛГАРУУЛАХ**

2.1 Зуучлагч хүлээн авагч улсын ажил олгогч, холбогдох байгууллагатай байгуулсан Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 7.1.1, 8.1.2-т заасан гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах гэрээгээр тохирсон эдийн засгийн салбар, ажлын байр, ажил мэргэжлийн захиалгад нийцүүлэн иргэнийг бүртгэнэ.

2.2 Зуучлагч гадаадад ажиллах хүсэлтэй иргэнд ажлын байрны санал, ажлын байрны нөхцөл, цалин хөлс, тухайн улсад төлөх нийгмийн даатгал, татварын талаар дэлгэрэнгүй мэдээлэл, зөвлөгөө өгнө.

2.3 Зуучлагч гадаадад ажиллах хүсэлтэй иргэнд мэдээлэл зөвлөгөө өгсний дараа хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын баталсан зуучлах үйлчилгээнд хамрагдах шалгах хуудас бөглүүлж бүртгэнэ.

2.4 Ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан иргэний хувийн хэрэг бүрдүүлэн хөтөлж, тухайн иргэнийг хүлээн авагч улсын ажил олгогчид зуучлахаар санал тавьж, сонгон шалгаруулалтанд хамруулна.

2.5 Зуучлагч Монгол Улсын хууль дүрэм журамд нийцүүлэн сонгон шалгаруулалт зохион байгуулах дотоод дүрэм баталж, мөрдөнө.

2.6 Уг дүрэмд зуучлуулагчид тавигдах шаардлага, сонгон шалгаруулалт зохион байгуулах дараалал, бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт зэргийг тодорхой тусгасан байна.

2.7 Уг дүрмийг батлахдаа Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөн байна.

### **Гурав. ЗУУЧЛАЛЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, БЭЛТГЭЛ ХАНГАХ**

3.1 Сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэнд хөдөлмөрийн нөхцөл, цалин хөлс, хангамж, нийгмийн даатгал, татвар төлөлтийн талаарх мэдээллийг өгч гадаадын ажил олгогчтой байгуулах хөдөлмөрийн гэрээний төслийг танилцуулж, тухайн иргэнийг хүлээн авагч улсын ажил олгогчтой зөвшилцөл хийж, хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг сайжруулах талаар хэлэлцээ хийнэ.

3.2 Зуучлагч нь хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрсний дараа зуучлуулагч иргэнтэй зуучлалын гэрээ байгуулна.

3.3 Зуучлалын гэрээнд дараах зүйлийг тусгана. Үүнд:

3.3.1 Зуучлагчаас зуучлуулагчид үзүүлэх үйлчилгээ;

3.3.2 Зуучлагчийг буруугаас болж зуучлуулагчид учирсан хохирлыг хэрхэн барагдуулах;

3.3.3 Зуучлагчийн өмнө зуучлуулагчийн хүлээх үүрэг;

3.3.4 Зуучлуулагчаас гарах шууд зардлийн хэмжээ;

3.3.5 Зуучлагч болон зуучлуулагчийн хооронд байгуулсан гэрээний талаарх маргааныг шийдвэрлэх;

3.3.6 Зуучлуулагчид тавигдах хэлний болон мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх;

3.3.7 Зуучлуулагчид тавигдах эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах;

3.3.8 Зуучлуулагчийн гэр бүлд үзүүлж болох үйлчилгээ.

3.4 Зуучлалын гэрээг байгуулахдаа зуучлуулагчаас аливаа дэнчин, урьдчилгаа, зуучлалын хураамж авахгүй байна.

3.5 Зуучлагч хүлээн авагч улсын ажил олгогчтой байгуулсан “Гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах гэрээ”-ний дагуу хүлээн авагч талаас зуучлалын хураамжийг авна.

3.4 Зуучлагч нь зуучлуулагчийг хүлээн авагч гадаад улсын хэлний болон гадаадад хөдөлмөр эрхлэхээр тохирсон ажил, мэргэжлийн чиглэлээр бэлтгэл хангуулах, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, визэнд оруулах зэрэг ажлыг зохион байгуулна.

3.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь явахын өмнөх бэлтгэл сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.

3.6 Сургалтын агуулгыг “Бэлтгэл сургалтын жишиг хөтөлбөр”-ийн дагуу боловсруулна. Бэлтгэл сургалтын жишиг хөтөлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батлана.

3.7 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Бэлтгэл сургалтын зардлын хэмжээг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон дээд хэмжээнээс доогуур тогтооно. Бэлтгэл сургалтын зардлын дээд хэмжээг Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналаар 2 жилдээ нэг удаа шинэчлэн тогтооно.

## **Дөрөв. ЗУУЧЛУУЛАГЧИД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ**

4.1 Зуучлагч нь зуучлуулагчийг тухайн ажлын байранд тогтвортой ажиллах, зайлшгүй шалтгаанаар өөр ажилд шилжин ажиллах, аливаа эрсдэл эрхийн зөрчлөөс хамгаалах, хууль ёсны ашиг сонирхлыг нь хамгаалах үүднээс өөрийн төлөөлөгчийг хүлээн авагч улсад ажиллуулна.

4.2 Зуучлагч нь гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа зуучлуулагчийн эрх ашгийг хамгаалах, хөдөлмөрийн маргааныг зохицуулж, хуулийн зөвлөгөө өгөх болон холбогдох үйлчилгээ үзүүлнэ.

4.3 Зуучлуулагчийн хүлээн авагч улсад очсоны дараах нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх, тухайн иргэнтэй байнгын холбоо харилцаатай байх зэргээр дэмжлэг үзүүлж, тэдний эрх ашиг хөндөгдөхөөс урьдчилан сэргийлж хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулахад хүлээн авагч байгууллагатай хэлэлцээ хийнэ.

4.4 Зуучлуулагчид болзошгүй эрсдэл учирсан тохиолдолд хүлээн Монгол Улсаас авагч улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар болон Консулийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төвөөс дэмжлэг тусалцаа авч, тухайн иргэний асуудлыг шийдэж болно.

4.5 Зуучлагч нь зуучлуулагчийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд гэр бүлийн хамт, эсхүл гэр бүл нь тодорхой хугацааны дараа очих боломжийн талаар хүлээн авагч тал болон ажил олгогчтой зөвшилцөнө. Хамт очсон болон тодорхой хугацааны дараа очсон бол гэр бүлийг нь зуучлуулагчийн нэг адил гэрээгээр хөдөлмөр эрхлэх болон нийгэм, ахуйн хангамжийн бусад нөхцөлөөр хангахад анхаарна.

4.6 Зуучлагч нь зуучлуулагч бүрийн хувийн хэрэг үүсгэн хөтөлж, буцаж ирсэн тохиолдолд хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллагад шилжүүлнэ.

4.7 Зуучлагч нь хөдөлмөрийн гэрээ дуусгавар болгоод буцаж ирсэн иргэнд нийгмийн даатгал, татварын буцаалтыг олгуулах арга хэмжээг авч ажиллана.

4.8 Буцан ирсэн иргэнийг нийгэмдээ буцаж нэгдэх, байр сууриа олоход нь дэмжлэг үзүүлэх зэргээр тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой.

4.9 Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т заасны дагуу буцан ирсэн иргэнийг дэмжих, төсөл, хөтөлбөрт хамруулахад дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллаж болно.

## **Тав.БУСАД**

5.1 Зуучлагч Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан эрх үүргийг эдлэнэ.

5.2 Зуучлуулагч иргэнийг зуучлалын тусгай зөвшөөрөлтэй болон зуучлалын тусгай зөвшөөрөлгүй байгууллагад шилжүүлэхгүй байна.

5.3 Зуучлалын хураамжийг зуучлуулагчаас авахыг хориглоно.

5.4 Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу байгуулсан гэрээ, санамж бичигт Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үйл ажиллагаа эрхлэхээр заасан тохиолдолд Зуучлах үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага оролцохгүй байна.

5.5 Их, дээд сургуульд мэргэжил эзэмшихэд зуучлах асуудал Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.11.заалтаар зохицуулагдах тул уг тусгай зөвшөөрөлд хамааралгүй болно.

### **Зургаа. ХАРИУЦЛАГА**

6.1 Тусгай зөвшөөрөлгүйгээр болон Тусгай зөвшөөрөлд зааснаас бусад улс болон чиглэлээр үйл ажиллагаа явуулсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.13 хэсэгт заасан зөрчилд тооцно.

6.2 Зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл аливаа хэлбэрээр худалдан борлуулах, бусдад шилжүүлсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

6.4 Зуучлуулагчаас төлбөр хураамж авсан, тусгай зөвшөөрлийг ашиглан залилан мэхэлсэн зэргээс үүдсэн хохирлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариуцахгүй болно.

-----o000o-----